



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/АЧ

Мандалговь

Цахим уралдаан зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн Сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын уламжлалт сар шинийн баярыг угтан “Үлгэрээ өвлүүлье цахим уралдаан”-ыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 20-ны өдрийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Уралдаан зохион байгуулах удирдамжийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Ц.Төрбилэг)-т үүрэг болгосугай.

3. Цахим уралдаанд шаардагдах 1.200.000 (Нэг сая хоёр зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийн орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Н.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100216